



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 1/10

Дэлгэрхаан сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх заалт, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/115 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, Боловсролын яамны нарийн бичгийн даргын 2025 “Шалгалтын тов тогтоох тухай” 2/203, Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/38 дугаар удирдамжийг тус тус үндэслэн тушаах нь:

1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ариунчимэг /Сургалтын менежер/

Гишүүд: О.Болд-Эрдэнэ /Мэдээллийн технологийн багш/

Б.Уранхайч /Математикийн багш/

Х.Бямбасүрэн /БАЗАН-ийн ахлагч/

Д.Лхагважав /БУЗАН-ийн ахлагч/

Д.Энхчимэг /НУЗАН-ийн ахлагч/

С.Цэцэгсайхан /Асран хамгаалагчийн төлөөлөл/

Х.Энэрэл /Сурагчийн төлөөлөл/

Нарийн бичиг: С.Саранчимэг /Нийгмийн ажилтан/

2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын байгууллага багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийг баримтлан удирдлага зохион байгуулалтаар ханган, анги танхим техник хэрэгслийг бэлтгэх, үнэлгээний нарийвчилсан зураглал, төлөвлөгөө гарган эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтанд мэдээлэн аливаа ёс зүйн зөрчилгүй ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж тайланг хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Ариунчимэг)-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Ш.ЦЭРЭНДУЛАМ

This PC/Desktop/Тушаал 2025

232511 0